

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2024/125/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын илрүүлэлт	14
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.02.25 № 270

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.ЭНХЭЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын шаардлага хангаагүй ажилтанд 28.8 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 5.2-т "Төрийн албанд хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг хянаж үзсэний үндсэн дээр төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох асуудлыг шийдвэрлэнэ", албан тушаалын чиг үүргийг давхардуулан хэвлэл мэдээлэл хариуцсан 2 ажилтан томилон 14.3 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"-ыг төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглоно гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нягтлан бодогч нь өөрийн ажлын байрны шууд харьяалах, хяналт тавих доод албан тушаалын буюу нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн санхүүгийн сахилга батыг мөрдөж, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажиллаагүй байна.

011021122

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга 92.3 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,228,000.0	22,005,300.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	5,678,300.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	5,678,300.0
35	БАРАА МАТЕРИАЛ	5,228,000.0	16,327,000.0
354	Хангамжийн материал	5,228,000.0	16,327,000.0
35410	Бичиг хэргийн материал	-	183,000.0
35420	Аж ахуйн материал	3,998,000.0	638,000.0
35470	Бусад хангамжийн материал	1,230,000.0	15,506,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	41,180,250.1	92,043,460.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	41,180,250.1	92,043,460.1
392	Биет хөрөнгө	39,961,500.1	91,199,710.1
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,340,000.0	32,340,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,288,333.4)	(11,678,333.4)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,854,470.7	36,506,330.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,352,145.5)	(20,875,329.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,952,958.0	50,502,933.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,545,449.6)	(12,040,889.7)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	16,445,000.0
393	Биет бус хөрөнгө	1,218,750.0	843,750.0
39301	Програм хангамж	2,850,000.0	1,500,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,631,250.0)	(656,250.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	46,408,250.1	114,048,760.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,678,300.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,678,300.0
413	Өглөг	-	5,678,300.0
4136	Бусад өглөг	-	5,678,300.0
41361	Байгууллагад төлөх өглөг	-	5,678,300.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	46,408,250.1	108,370,460.1
51	Засгийн газрын хувь оролцоо	46,408,250.1	108,370,460.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,169,756.8	60,169,756.8
51101	Өмч: - төрийн	60,169,756.8	60,169,756.8
512	Хуримтлагдсан үр дүн	(17,184,774.7)	44,777,435.3
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,323,776.8)	(17,184,774.7)
51220	Тайлант үеийн үр дүн	(11,860,997.9)	61,962,210.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,423,268.0	3,423,268.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	46,408,250.1	114,048,760.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,413,130,300.0	3,050,961,950.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	76,343,250.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	76,343,250.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	76,343,250.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	76,343,250.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,413,130,300.0	2,974,618,700.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,567,200,000.0	2,230,800,300.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,567,200,000.0	2,230,800,300.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	845,930,300.0	743,818,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	845,930,300.0	743,818,400.0

**Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,424,991,297.9	2,988,999,740.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,424,991,297.9	2,988,999,740.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,410,993,025.0	2,952,335,301.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,902,894.1	350,844,313.4
210101	Үндсэн цалин	164,937,216.4	203,007,381.0
210102	Нэмэгдэл	37,122,167.4	106,975,245.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,460,000.0	14,854,999.9
210104	Урамшуулал	17,383,510.2	26,006,687.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,309,569.0	43,911,009.7
210201	Тэтгэврийн даатгал	19,250,509.0	30,870,182.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,264,763.0	3,628,259.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,811,811.0	2,802,934.0
210204	Ажилгүйдлийн даатгал	452,953.0	594,956.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,529,533.0	6,014,678.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	469,500.0	-
210304	Байрны түрээс	469,500.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,344,418.0	25,535,780.0
210401	Бичиг хэрэг	2,254,100.0	2,922,000.0
210402	Тээвэр, шатахуун	16,019,738.0	16,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,689,658.0	1,515,480.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	380,922.0	398,300.0
210408	Бараа материал акталсны зардал	-	4,700,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,480,235.0
210604	Урсгал засвар	-	7,480,235.0
2107	Томилолт, зочны зардал	15,188,200.0	17,909,600.0
210702	Догоод албан томилолт	13,774,700.0	17,909,600.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,413,500.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	518,794,876.0	254,269,428.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	518,664,858.0	254,139,410.0
210803	Даатгалын үйлчилгээ	74,250.0	74,250.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,768.0	33,768.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	22,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,597,983,567.9	2,252,384,935.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,568,600,000.0	2,226,822,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,022,570.0	13,859,895.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,360,997.9	11,703,040.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,998,273.0	36,664,439.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,991,400.0	30,665,925.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,805,925.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,991,400.0	1,860,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,006,873.0	5,998,514.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,006,873.0	5,998,514.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11,860,997.9)	61,962,210.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(11,860,997.9)	61,962,210.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,413,130,300.0	2,968,940,400.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,413,130,300.0	2,968,940,400.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,567,200,000.0	2,225,122,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,567,200,000.0	2,225,122,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	845,930,300.0	743,818,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	845,930,300.0	743,818,400.0

**Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,413,130,300.0	2,968,940,400.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,413,130,300.0	2,968,940,400.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,399,132,027.1	2,932,275,961.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,902,894.1	350,844,313.4
210101	Үндсэн цалин	164,937,216.4	203,007,381.0
210102	Нэмэгдэл	37,122,167.4	106,975,245.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,460,000.0	14,854,999.9
210104	Урамшуулал	17,383,510.2	26,006,687.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,309,569.0	43,911,009.7
210201	Тэтгэврийн даатгал	19,250,509.0	30,870,182.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,264,763.0	3,628,259.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,811,811.0	2,802,934.0
210204	Ажилгүйдлийн даатгал	452,953.0	594,956.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,529,533.0	6,014,678.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	469,500.0	-
210304	Байрны түрээс	469,500.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	20,344,418.0	21,018,780.0
210401	Бичиг хэрэг	2,254,100.0	3,105,000.0
210402	Тээвэр, шатахуун	16,019,738.0	16,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,689,658.0	1,515,480.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	380,922.0	398,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	8,242,135.0
210604	Урсгал засвар	-	8,242,135.0
2107	Томилолт, зочны зардал	15,188,200.0	17,909,600.0
210702	Дотоод албан томилолт	13,774,700.0	17,909,600.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,413,500.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	520,294,876.0	249,668,228.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	518,664,858.0	249,538,210.0
210803	Даатгалын үйлчилгээ	74,250.0	74,250.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,768.0	33,768.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,584,622,570.0	2,240,681,895.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,568,600,000.0	2,226,822,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,022,570.0	13,859,895.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,998,273.0	36,664,439.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,991,400.0	30,665,925.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,805,925.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,991,400.0	1,860,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,006,873.0	5,998,514.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,006,873.0	5,998,514.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
S01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	60,169,756.8	3,423,268.0	(5,323,776.8)	58,269,248.1
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,169,756.8	3,423,268.0	(5,323,776.8)	58,269,248.1
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
S07	Тайланг үеийн үр дүн	-	-	(11,860,997.9)	(11,860,997.9)
S08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.8	3,423,268.0	(17,184,774.7)	46,408,250.1

**Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	60,169,756.8	3,423,268.0	(17,184,774.7)	46,408,250.1
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,169,756.8	3,423,268.0	(17,184,774.7)	46,408,250.1
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	61,962,210.0	61,962,210.0
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.8	3,423,268.0	44,777,435.3	108,370,460.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	743,818,300.0	737,819,886.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743,818,300.0	737,819,886.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	711,618,300.0	707,153,961.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,698,900.0	350,844,313.4
210101	Үндсэн цалин	217,758,900.0	203,007,381.0
210102	Нэмэгдэл	100,380,000.0	106,975,245.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,360,000.0	14,854,999.9
210104	Урамшуулал	18,200,000.0	26,006,687.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,212,400.0	43,911,009.7
210201	Тэтгэврийн даатгал	30,064,400.0	30,870,182.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,537,000.0	3,628,259.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,829,600.0	2,802,934.0
210204	Ажилгүйдлийн даатгал	707,400.0	594,956.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,074,000.0	6,014,678.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,305,000.0	21,018,780.0
210401	Бичиг хэрэг	3,105,000.0	3,105,000.0
210402	Тээвэр, шатахуун	16,000,000.0	16,000,000.0
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	1,800,000.0	1,515,480.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.0	398,300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.0	8,242,135.0
210604	Урсгал засвар	8,500,000.0	8,242,135.0
2107	Томилолт, зочны зардал	18,000,000.0	17,909,600.0
210702	Дотоод албан томилолт	18,000,000.0	17,909,600.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	250,141,000.0	249,668,228.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	250,009,000.0	249,538,210.0
210803	Даатгалын үйлчилгээ	75,000.0	74,250.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,000.0	33,768.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	22,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,761,000.0	15,559,895.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.0	1,700,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,861,000.0	13,859,895.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,200,000.0	30,665,925.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,200,000.0	30,665,925.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,000,000.0	28,805,925.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.0	1,860,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	743,818,400.0	737,819,886.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	743,818,400.0	737,819,886.1
122005	Орон нутгийн төсвөөс	743,818,400.0	737,819,886.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,225,122,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,225,122,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,225,122,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,225,122,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,225,122,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,225,122,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,225,122,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,225,122,000.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43.1 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 28.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 14.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон ажиллах 1 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын шалгуур хангаагүй ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д "Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно, ..." гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- Нягтлан бодогч нь өөрийн ажлын байрны шууд харьяалах, хяналт тавих доод албан тушаалын буюу нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн байна. Энэ нь нягтлан бодогчийн ажлын байрны албан тушаалын тодорхойлолт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Албан тушаалын чиг үүргийг давхардуулан хэвлэл мэдээлэл хариуцсан 2 ажилтан томилон, төсвөөс 12.7 сая төгрөгийн цалин, 1.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, нийт 14.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"-ыг төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглоно гэж заасныг зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тус газрын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон өөрчлөөгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т нийцүүлэн тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгох.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ". Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нягтлан бодогч нь өөрийн ажлын байрны шууд харьяалах, хяналт тавих доод албан тушаалын буюу нярвын ажлыг давхар гүйцэтгэсэн байна.	1	0.0	-	-	1	0.0	-	-	-	-	-	-
"Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын шаардлага хангаагүй ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон	1	28,805.9	1	28,805.9	-	-	-	-	-	-	-	-
Албан тушаалын чиг үүргийг давхардуулан	1	14,316.3	-	-	1	14,316.3	-	-	-	-	-	-

**Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

хэвлэл мэдээлэл хариуцсан 2 ажилтан томилж, төсвөөс цалин олгосон												
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон өөрчлөөгүй.	1	0	-	-	-	-	1	0	-	--	--	-
Дүн	4	43,122.2	1	28,805.9	2	14,316.3	1	0,0	-	-	-	-